

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

20 *24* оны *03* сарын *26*-ны өдөр

№ *10*

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын бүтцийг шинэчлэн батлах тухай

Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.1, 81.2 дахь хэсгүүд болон “Сэндли ББСБ” ХК (*цаашид “Компани” гэх*)-ийн дүрмийн холбогдох хэсгүүдийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Сэндли ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодыг дараах байдлаар шинэчлэн байгуулсугай.
 - 1.1. Аудит, эрсдэлийн удирдлагын хороо
 - 1.2. Цалин урамшууллын хороо
 - 1.3. Нэр дэвшүүлэх хороо

2. Шинэчлэн байгуулагдсан Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнд дараах өөрчлөлтийг оруулан, шинэчлэн байгуулсугай.
 - 2.1. Аудит, эрсдэлийн удирдлагын хороо
Хорооны дарга: ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Цэлмэг
Гишүүд: ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Анужин
ТУЗ-ийн ердийн гишүүн Н.Билгүүн
 - 2.2. Цалин урамшууллын хороо
Хорооны дарга: ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Анужин
Гишүүд: ТУЗ-ийн хараат бус гишүүн Ц.Саруултуяа
ТУЗ-ийн ердийн гишүүн Б.Эрдэнэ
 - 2.3. Нэр дэвшүүлэх хороо
Хорооны дарга: ТУЗ-ийн хараат бус гишүүн Ц.Саруултуяа
Гишүүд: ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Цэлмэг
ТУЗ-ийн ердийн гишүүн Л.Нарантуяа

3. Хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмыг мөрдөж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, компанийн дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмын дагуу бүрэн эрхээ хэрэгжүүлж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

4. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын үйл ажиллагааг явуулахад шаардагдах зардлыг санхүүжүүлэхийг Гүйцэтгэх захирал (Б.Одгэрэл)-д, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамд холбогдох өөрчлөлтийг тусган, батлуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн ийн нарийн бичгийн дарга (Э.Цэлмэг) нарт тус тус үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.НАРАНБАТ

